

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН  
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 05 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугараас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 04 дүгээр сарын 25, 05 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар тус тус явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн зарим зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд хууль, тогтоолын төслийн заалт хооронд зөрчил үүсгэхээр байсан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь эдгээр саналуудаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзэж дараах санал хураалтуудыг явууллаа.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг “14.3.олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас баталсан нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно” гэсэн зарчмын зөрүүтэй санал болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийг хуулийн төслийн холбогдох заалттай нийцүүлэх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь буюу дийлэнх олонх нь дэмжсэн болно.

Эдийн засгийн байнгын хороо чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хууль, тогтоолын төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дарааллыг жигдлэх хууль зүйн техникийн засваруудыг хийж, хууль, тогтоолын төслийн эцсийн хувилбар болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим

арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ



**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН  
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгасан санал:**

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3. Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас баталсан нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно.”

**Санал гаргасан: ЭЗБХ**

-----oOo-----

**“ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгасан санал:**

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “зургаа хүртэлх” гэснийг “таван” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: ЭЗБХ**

-----oOo-----

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зээлийн мэдээллийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

#### **1/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:**

“10.3. Энэ хуулийн 10.1, 10.2-т зааснаас өөр зорилгоор зээлийн мэдээллийг ашиглахыг хориглоно.”

#### **2/14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:**

~~“14.3. Энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг Монголбанкнаас баталсан онооны аргачлалын дагуу тогтооне.”~~

**“14.3. Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас тогтоосон нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бутээгдэхүүн, үйлчилгээний хэлсийг тогтооно.”**

**“14.3. Зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг Монголбанкнаас заасан зарчмыг баримтлан, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд тогтооно.”**

**2 дугаар зүйл.** Зээлийн мэдээллийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.2. Зээлийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтооход ашиглана.”

**3 дугаар зүйл.** Зээлийн мэдээллийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг “эургаан” гэснийг **“таван”** гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох онооны аргачлал болон зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд зургаа хүртэлх жилээр тусгах нөхцөл, шалгуурыг дараах нөхцөлийг харгалзан батлахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д даалгасугай:

1/иргэн, хувийн өмчит хуулийн этгээдийн зээлийн ангилал давагдашгүй хүчин зүйлээс хамаарч хэвийн ангиллаас бусад ангилалд орсон бөгөөд зээлийн өр, төлбөрөө бүрэн төлсөн тохиолдолд, түүнчлэн бусад нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг уян хатан тогтоох;

2/иргэн, хувийн өмчит хуулийн этгээдийн зээлийн төрөл, зээлийн өр, төлбөрийг бүрэн төлж барагдуулсан хугацаанаас хамаарч зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг уян хатан тогтоох;

3/энэ тогтоолын 1 дэх заалтын 1, 2 дахь дэд заалтад төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллагын дэргэдэх сангаас болон Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан зээлээ хугацаандаа төлөөгүй, түүнчлэн хэвийн зээлийн ангиллаас бусад ангилалд орсон иргэн, аж ахуйн нэгж, түүний зээлийн мэдээллийг хамааруулахгүй байх.

2.Зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох онооны аргачлалыг хөлбөгдох байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хөрөө /Д.Баярсайхан/-д тус тус даалгасугай.

**“2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бутээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл шаардлагыг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Т.Жамбаажамц/-д тус тус даалгасугай.“**

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

Гарын үсэг